

**Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид хуралдлаа**

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид 6-н сард 2 удаа хуралдан 5-н асуудлыг авч хэлэлцлээ. Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв.

**1. Хүнсний зах, худалдаа**

үйлчилгээний төвүүдийн үйлчилгээний стандарт хангуулах, орчин нөхцлийг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай

2. “Хөндөгдсөн газарт нөхөн сэргээлт хийх журам”-д өөрчлөлт оруулах санал хэлэлцэх тухай

**3. Орон нутгийн төсвийн тухай**

-Зарим хөрөнгө оруулалтыг өөрчлөх санал хэлэлцэх

- Хөрөнгө оруулалтын ажлын нэрийг өөрчлөх тухай

**4. ОНӨ актлах, худалдах тухай****5. Шагналд тодорхойлох тухай**

Нэгдүгээр асуудлын хүрээнд 6-р сардаа багтаан холбогдох төрийн байгууллагууд, худалдаа эрхлэгчид, захын эзэдтэй хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллаж үр дүнг аймгийн ИТХ-д танилцуулж хэрэгжилтийг хангаж ажиллахыг Улаангом сумын ИТХ-ын дарга Б.Жавхлантөгс, Засаг дарга О.Ганхуяг нарт хурлын тэмдэглэлээр үүрэг болгов.

Хоёрдугаар асуудлын хүрээнд 3.2-р заалт нь ашигт малтмалын хуулийн 7.3-р зүйлтэй зөрчилдөж байгаа тул хасаж нөхөн сэргээлт хийх ажлын санхүүжилт гэсэн 3 заалт бүхий бүлэг нэмж оруулав. Ингэснээр нөхөн сэргээлт хийх ажлын санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсөв, олон улсын төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр хийхээр өөрчлөлт оруулав.

Мөн МУ-ын Ерөнхийлөгчийн тамгын газарт Ардын жүжигчин-1, Сүхбаатарын одон-1, МУ-ын гавьяат цолоор 2, ХГУТО-оор 3, АГО-оор 19, ХХМ-иар 36 хүнийг шагнуулахаар өргөн мэдүүлээ.

**“Улаангом сумын хог хаягдлын менежментийг сайжруулах нь” сэдэвт семинар боллоо**

Увс аймгийн түүхт 90 жилийн ойг тохиолдуулан “ӨӨРЧЛӨЛТИЙГ ӨӨРӨӨСӨӨ ЭХЛЭЭ” хөдөлгөөн, “МИНИЙ ГЭРЭЭС МАНАЙ АЙМГИЙН ХӨГЖИЛ ЭХЭЛНЭ” аяны хүрээнд “Улаангом сумын Хог хаягдлын менежментийг сайжруулах нь сэдэвт семинар Аймгийн ИТХ-ын хуралдааны танхимд болж байна. Семинарыг Улаангом сумын ИТХ, ЗДТГ-аас УБ хотын ЭЛЕМЕНТ ХХК-ны эрүүл ахуйч эмч Н.Болор, мэргэжилтэн Б.Энхбадрал, менежер О.Дорж, Улаанбаатар хотын захирагчын ажлын албаны тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн С.Аригуун нар хамтран удирдан зохион байгуулж байна.



Хэлэлцүүлэгт: МХГ, ХХЦГ, Улаангом сумын удирдлагууд, Багийн Засаг дарга, Нийгмийн ажилтнууд, Сургуулийн нийгмийн ажилтнууд, Өрхийн эмнэлэг, цэцэрлэгийн эмч нар, Байгаль орчны байцаагч нар зэрэг 100 гаруй хүн оролцлоо.

**Баруун бүсийн Аймгуудын НӨУБ-ын сонгуультаан, ажилтнуудын уулзалт, спортын тэмцээн**

Жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг “Баруун бүсийн аймгуудын НӨУБ-ын сонгуультаан, ажилтнуудын уулзалт, спортын тэмцээн” энэ жил Баян-Өлгий аймгийн Өлгий хотноо 06 сарын 03-05-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа.



Энэ удаагийн уулзалтанд Баян-Өлгий, Увс, Ховд, Говь-Алтай аймгийн ИТХ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга, Тэргүүлэгч, Төлөөлөгч, ажлын албаны ажилтнууд зэрэг 60 гаруй төлөөлөл оролцлоо.

Уулзалт хэлэлцүүлгийн үеэр НӨУБ-ын бүрэн эрхийг зөрчсөн МУЗЗНДНТУТ хууль болон Төсвийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болгуулах мөн бүс нутгийн хэмжээнд шийдвэрлэх зарим асуудлын талаар 16 зүйл бүхий санал санаачлагыг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр боллоо.

**“Төлөөлөгчдийн манлайлал” үндэсний сэдэвчилсэн II сургалт боллоо**

Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Нутгийн өөрөө удирдах байгууллагийн чадавхыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд зохион байгуулагдаж байгаа Аймаг, сумдын ИТХ-ын Тэргүүлэгч, Нарийн бичгийн дарга нарт зориулсан “Төлөөлөгчдийн манлайлал” үндэсний сэдэвчилсэн II сургалт 06 сарын 08-11 өдрүүдэд Улаангом хотноо зохион байгуулагдаж байна. Сургалтанд Увс аймгийн 19 сумын ИТХ-ийн тэргүүлэгч, Нарийн бичгийн дарга нар нийт 150 хүн оролцож байна. Сургалтыг орон нутгаас сургагч багшаар



бэлтгэгдсэн Б.Оюунбат, ИТХ-ийн ажлын албаны мэргэжилтэн Н.Энхжаргал, Сайн тус ТББ-ын тэргүүн Д.Тогтох нар зохион байгуулж байна. Сургалтын дараах ерөнхий агуулгын хүрээнд зохион байгуулж байна. Үүнд

- ◆ Төлөөлөгчийн Манлайлал, Манлайлагчийн хөгжил
- ◆ Хяналт-шинжилгээ, үнэлгээ буюу Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн биелэл тооцох нь
- ◆ Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдөд судалгаа-шинжилгээ хийх арга зүйг эзэмшүүлэх нь
- ◆ Нутгийн өөрөө удирдах байгууллагаас бусад байгууллагатай харилцах үйл ажиллагааны үндсэн хэлбэрүүд гэсэн үндсэн 4 бүлэг сэдвийн хүрээнд явагдлаа.



2015 оны 06-р сар

### “ИХ НАЯДЫН УВС” баруун бүсийн хөрөнгө оруулалтын чуулган болов

Баруун бүсийн хөрөнгө оруулалтын чуулган 2015 оны 6-р сарын 25-26-ны өдрүүдэд Улаангом хотноо амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Энэ удаагийн чуулганд Баруун таван аймгийн удирдлага, Франц, Тайван, ШУӨЗО-ны Алтай аймаг, ОХУ-ын Тува улс, Дэлхийн банкны суурин төлөөлөгч, УУЯ, МҮХАҮТ-ын дарга зэрэг гадна дотны нийт 450 гаруй зочид төлөөлөгчид оролцлоо.



Чуулган эхний өдөр чуулганы зохион байгуулагч, оролцогч аймгуудын төлөөлөл, гадны зочид илтгэлээ танилцуулж, 2 дахь өдөр Увс аймагт хэрэгжих хөрөнгө оруулалтын, болон хамтран ажиллах 12 төрлийн гэрээнд гарын үсэг зурлаа.

### “УВС ДАХЬ АРДЧИЛСАН ЗАСАГЛАЛЫН 1000 ӨДӨР”

Увс аймаг 2014 оны ажлын амжилтаараа Улсын шилдэг аймгаар шалгарсан. Аймгийнхаа Түүх 90 жилийн ойн өмнө тохиосон энэ баярт үйл явдлыг иргэд, хувийн хэвшлийнхэнтэйгээ хуваалцаж, Засгийн газрын шилдэг аймаг гэсэн соёрхлыг хүртээх арга хэмжээг 2015 оны 6 сарын 15-ны өдөр Маршал Ю.Цэдэнбалын талбайд зохион байгуулагдлаа.

Төр хувийн хэвшлийн түншлэлийг ажил хэрэг



болгож, Хувийн хэвшилд итгэл үзүүлж, бизнесийн орчинг сайжруулах бодлого хэрэгжүүлсний үр дүнд Өрсөлдөх чадварын үнэлгээгээр Увс аймаг хоёр жил дараалан баруун бүсээ тэргүүлж байна. Орон нутагтаа баялаг бүтээж байгаа хувийн хэвшлийнхэн, хөдөлмөр, зүтгэлтэйгээ ажиллаж амьдарч буй иргэддээ, төрийн бодлого шийдвэрийг амжилттай хэрэгжүүлж байгаа төрийн албан хаагчиддаа Монгол Улсын шилдэг аймгийн Соёрхлыг ийнхүү хуваалцаж, нутгийн зон олондоо, урам өгсөн арга хэмжээ боллоо.

### Зүүнхангай сум:

#### Сумын хөгжлийн алсын хараа:

Уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуй, орон нутгийн нөөцөд түшиглэсэн жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ, туслах аж ахуй, дэд бүтэц хөгжсөн хүний хөгжлийн чадавхтай зүүн бүсийн эдийн засагт нөлөө бүхий хөгжиж буй сум болно. Гэж үзээд өмнө нь боловсролыг хөгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулан баталсан бол

Одоо нутгийн бүх эрдэмтэн мэргэд томоохон албаны хүмүүсээ түшиж сумын 2030 он хүртэлх хөгжлийн иж бүрэн хөтөлбөрийг боловсруулах ажлыг эхлүүлхээр Нутгийн зөвлөл, суманд комиссууд байгуулагдан ажилдаа орж эхэллээ.

Мөн энэ жилийн хувьд хуурайшилт ихтэй цаашид ган болох төлөвтэй байсан тул сүсэгтэн олны хүчийг ашиглан овоо тахилга үйлдэн тэрхүү овоонд “Луваанжалба” бурханыг авч ирүүлэн залж наадам зохион байгуулснаар ган тайлагдаж зуншлага сайжирлаа.

#### Бөхмөрөн сум:

#### ГХУСАЗСэргийлэх мэдээ, мэдээлэлийн самбартай боллоо

Сумын ГХУСАЗСөвлөлөөс Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, яриа таниулага, ухуулага, анхааруулага бүхий хулдаасан хэвлэл байршуулах зорилгоор сумын төвруу орох, гарах 2 гарцанд 2 м урт, 1,3 м өргөнтэй 2 ширхэг листэн төмөр самбар хийж, хулдаасан хэвлэл байршууллаа.

Дээрх 2 ширхэг самбар хийж, байрлуулсанаар сумын ГХУСАЗСөвлөл нь өөрийн мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлэг,

анхааруулага бүхий зурагт хуудас байршуулах өөрийн гэсэн самбартай боллоо.



### Давст сум:



Сумын 90-н жилийн ой тохиолдуулан бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил хийгдэж

байна. Үүнд: Албан байгууллагуудын тохижилт, гадна орчноо тохижуулах, айл хороололын хашаа хороогоо шинэчлэх зэрэг ажлууд явагдаж байна.



### Хаяг

Увс аймаг, Улаангом хот, 3-р баг Ө.Бадрахын гудамж, ЗДТГ-ын байр 210тоот

Утас :70453627

Факс :70452214

И Мэйл:

info@khural.uv.gov.mn

Вэб сайт:

http://uvs.khural.mn/

Facebook:

www.facebook.com/groups/uvs.ith